

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Халиун сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599

Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Агуулга	1
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 52
танай _____ -ны № _____ -т

ХАЛИУН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.БАДАРЧ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халиун сумын Засаг даргын тамгын газрын даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Халиун сумын Засаг даргын тамгын газрын даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй, анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан, төсвийн хэмнэлтийн гормыг зөрчиж ажилласан, малжуулалтын гэрээ дууссан байхад гэрээний дагуу дараагийн айлд шилжүүлээгүй, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт зөрүүтэй зэрэг 149.2 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Малчидтай байгуулсан гэрээ, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07120125

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,969,570.00	263,665,270.00
33	АВЛАГА	30,168,465.00	14,168,465.00
33500	Бусад авлага	30,168,465.00	14,168,465.00
33510	Байгууллагаас авах авлага	16,000,000.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	14,168,465.00	14,168,465.00
33600	Зээлийн авлага	0.00	0.00
35400	Хангамжийн материал	22,647,985.00	44,213,285.00
35410	Бичиг хэргийн материал	397,500.00	803,000.00
35420	Аж ахуйн материал	22,250,485.00	43,410,285.00
35600	Мал амьтад	92,153,120.00	93,973,120.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	111,310,400.00
36100	Барааны нөөц	0.00	0.00
36200	Үрийн нөөц	0.00	106,010,400.00
36300	Тэжээлийн нөөц	0.00	5,300,000.00
36400	Шатахууны нөөц	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	921,271,847.13	905,409,319.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	921,271,847.13	905,409,319.90
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	915,984,847.13	900,182,319.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	647,239,330.78	652,120,480.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,326,085.77	-101,673,829.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,372,800.00	113,852,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,528,700.04	-96,352,800.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	137,313,997.14	132,972,093.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-118,370,191.63	-105,204,098.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,492,703.57	61,250,773.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,273,585.81	-59,133,872.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	435,976,573.99	503,246,473.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	-166,342,895.10	-201,326,601.88
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	430,900.00	430,900.00
39300	Биет бус хөрөнгө	5,287,000.00	5,227,000.00
39301	Программ хангамж	2,480,000.00	2,480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,490,000.00	-1,550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,297,000.00	4,297,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,066,241,417.13	1,169,074,589.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,066,241,417.13	1,169,074,589.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,066,241,417.13	1,169,074,589.90
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	418,800,564.27	418,800,564.27
51200	Хуримтлагдсан үр дүн	417,518,284.99	546,064,454.16
51210	Өмнөх үеийн үр дүн	490,548,454.81	443,231,281.39
51220	Тайлант үеийн үр дүн	-73,030,169.82	102,833,172.77
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	229,922,567.87	204,209,571.47

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,066,241,417.13	1,169,074,589.90
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	349,073,834.00	593,152,723.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,396,720.00	215,476,705.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,396,720.00	207,726,705.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,396,720.00	150,456,805.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,138,500.00	972,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,258,220.00	149,484,805.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	57,269,900.00
122	Тусламжийн орлого	0.00	7,750,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	7,750,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,677,114.00	377,676,018.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,482,714.00	30,819,418.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	325,194,400.00	346,856,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	325,194,400.00	346,856,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	403,737,577.82	490,319,550.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,737,577.82	490,319,550.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,441,124.90	485,040,118.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,490,816.84	229,612,094.89
210101	Үндсэн цалин	115,021,448.98	129,442,029.51
210102	Нэмэгдэл	30,943,186.07	44,453,959.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	40,165,479.49	37,694,336.94
210105	Гэрээт ажлын хөлс	17,360,702.30	18,021,768.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,147,077.07	27,993,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,442,371.52	19,207,146.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,025,664.60	2,213,007.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,640,739.08	1,770,046.08
210204	Ажилгүйдлийн даатгал	380,537.28	437,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,657,764.59	4,366,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,540,160.17	24,165,271.41
210301	Гэрэл, цахилгаан	3,740,160.17	3,341,927.41
210302	Түлш, халаалт	18,600,000.00	20,743,344.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	80,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,172,080.00	44,802,318.00

210401	Бичиг хэрэг	2,158,360.00	2,815,550.00
210402	Тээвэр, шатахуун	17,746,900.00	25,836,193.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,727,370.00	1,438,330.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	999,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,320,250.00	694,845.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	13,017,400.00
210408	Бараа материал акталсны зардал	2,220,200.00	0.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	575,500.00	5,625,405.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	575,500.00	5,625,405.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,932,500.00	4,036,550.00
210604	Урсгал засвар	3,932,500.00	4,036,550.00
2107	Томилолт, зочны зардал	3,532,000.00	2,665,600.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,532,000.00	2,665,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,311,527.00	11,129,602.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,135,568.00	10,002,113.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,100.00	181,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,188.00	117,850.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	102,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	253,671.00	285,689.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,739,463.82	135,009,577.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,529,200.00	26,352,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	84,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,710,263.82	108,573,577.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,296,452.92	5,279,431.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,496,800.00	5,196,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,496,800.00	5,196,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	83,431.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	83,431.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,799,652.92	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,948,806.92	0.00
213404	Хөрөнгийн	0.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,850,846.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-54,663,743.82	102,833,172.77
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,366,426.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	18,366,426.00	0.00

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-73,030,169.82	102,833,172.77
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	347,436,614.00	386,398,018.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,138,500.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,138,500.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,138,500.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,138,500.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	346,298,114.00	386,398,018.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,103,714.00	39,541,418.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,501,214.00	9,643,418.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	602,500.00	26,398,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	325,194,400.00	346,856,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	325,194,400.00	346,856,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	328,857,614.00	372,498,018.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,857,614.00	372,498,018.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,561,161.08	367,218,586.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,490,816.84	229,612,094.89
210101	Үндсэн цалин	115,021,448.98	129,442,029.51
210102	Нэмэгдэл	30,943,186.07	44,453,959.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	40,165,479.49	37,694,336.94
210105	Гэрээт ажлын хөлс	17,360,702.30	18,021,768.85
210106	Ажилсагчдад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,147,077.07	27,993,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,442,371.52	19,207,146.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,025,664.60	2,213,007.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,640,739.08	1,770,046.08
210204	Ажилгүйдлийн даатгал	380,537.28	437,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,657,764.59	4,366,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,540,160.17	24,165,271.41
210301	Гэрэл, цахилгаан	3,740,160.17	3,341,927.41

210302	Түлш, халаалт	18,600,000.00	20,743,344.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	80,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,652,380.00	31,526,353.00
210401	Бичиг хэрэг	2,252,860.00	3,190,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,746,900.00	24,898,023.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,727,370.00	1,438,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	999,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	926,250.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	575,500.00	2,481,800.00
210502	Хоол, хүнс	575,500.00	2,481,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,282,500.00	8,953,200.00
210604	Урсгал засвар	4,282,500.00	8,953,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,532,000.00	2,665,600.00
210702	Дотоод албан томилолт	3,532,000.00	2,665,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,311,527.00	13,384,567.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,135,568.00	12,257,078.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,100.00	181,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	126,188.00	117,850.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	102,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	253,671.00	285,689.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,029,200.00	26,436,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,529,200.00	26,352,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	84,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,296,452.92	5,279,431.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,496,800.00	5,196,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,496,800.00	5,196,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	83,431.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	83,431.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,799,652.92	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,948,806.92	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,850,846.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,579,000.00	13,900,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,579,000.00	13,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,579,000.00	13,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,579,000.00	13,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,579,000.00	13,900,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-18,579,000.00	-13,900,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,800,564.27	229,922,567.87	490,548,454.81	1,139,271,586.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,800,564.27	229,922,567.87	490,548,454.81	1,139,271,586.95
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-73,030,169.82	-73,030,169.82
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,800,564.27	229,922,567.87	417,518,284.99	1,066,241,417.13
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	418,800,564.27	229,922,567.87	417,518,284.99	1,066,241,417.13
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-25,712,996.40	25,712,996.40	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,800,564.27	204,209,571.47	443,231,281.39	1,066,241,417.13
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	102,833,172.77	102,833,172.77
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	418,800,564.27	204,209,571.47	546,064,454.16	1,169,074,589.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	348,256,600.00	346,852,368.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,256,600.00	346,852,368.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,056,600.00	341,656,368.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,548,400.00	219,532,094.89
210101	Үндсэн цалин	125,047,800.00	119,362,029.51
210102	Нэмэгдэл	37,094,000.00	44,453,959.59
210104	Урамшуулал	39,454,400.00	37,694,336.94
210105	Гэрээт ажлын хөлс	17,952,200.00	18,021,768.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,993,700.00	27,993,700.00
210201	Тэтгэврийн даатгал	19,252,700.00	19,207,146.34

210202	Тэтгэмжийн даатгал	2,187,500.00	2,213,007.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,750,000.00	1,770,046.08
210204	Ажилгүйдлийн даатгал	437,500.00	437,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,366,000.00	4,366,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,321,400.00	24,165,271.41
210301	Гэрэл, цахилгаан	3,387,000.00	3,341,927.41
210302	Түлш, халаалт	20,854,400.00	20,743,344.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	80,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,778,800.00	25,427,513.00
210401	Бичиг хэрэг	3,190,000.00	3,190,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,800,000.00	18,799,183.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,788,800.00	1,438,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,582,200.00	15,582,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,400,000.00	6,400,000.00
210602	Тавилга	1,500,000.00	1,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	7,682,200.00	7,682,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,956,800.00	2,665,600.00
210702	Дотоод албан томилолт	2,956,800.00	2,665,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,207,600.00	9,763,989.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,080,000.00	8,636,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	182,000.00	181,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,900.00	117,850.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,000.00	102,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	285,700.00	285,689.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,067,700.00	15,926,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,942,400.00	15,842,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	125,300.00	84,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,200,000.00	5,196,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,200,000.00	5,196,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,200,000.00	5,196,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	348,256,600.00	346,856,600.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	348,256,600.00	346,856,600.00

320001	Орон нутгийн төсвөөс	348,256,600.00	346,856,600.00
--------	----------------------	----------------	----------------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		39,541,418.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		39,541,418.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		39,462,218.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,080,000.0
210101	Үндсэн цалин		10,080,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал		6,098,840.0
210402	Тээвэр, шатахуун		6,098,840.0
2105	Нормативт зардал	-	1,881,800.0
210502	Хоол, хүнс		1,881,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,271,000.0
210604	Урсгал засвар		7,271,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,620,578.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,620,578.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,510,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,510,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	79,200.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	79,200.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		79,200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	39,541,418.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	30,819,418.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,500,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,643,418.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	17,676,000.0
131106	Төсвийн урамшуулал	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		972,000.0

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		972,000.0
122	Тусламжийн орлого		7,750,000.0
122001	Хандив тусламж /дотоод/		7,750,000.0
122002	Хандив тусламж /гадаад/		

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халиун сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Халиун сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Халиун сумын Засаг даргын тамгын газар нь: Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж болон бусад бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулан ажиллах шаардлагатай байна. Иймд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халиун сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 403.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 490.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халиун сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.7 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний ба эцсийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 30.1 сая төгрөг, үүнээс 16.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг хийснээр авлагыг барагдуулж эцсийн үлдэгдэл 14.2 сая төгрөгийн байгаа нь цалингийн нөхөр олговрын авлага байна.

Өглөгийн эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 138.1 сая төгрөг болж 23.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 40.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 148.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө орлогоор тайлагнаж, үйл ажиллагаандаа 55.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 905.0 сая төгрөг болж буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,169.1 сая төгрөг болж 102.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 546.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 316.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсөв захирагч 34.8 сая төгрөгөөр өсгөж, 351.3 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон төсвөөс санхүүжүүлэхээр 351.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс нутгийн төсвөөс 346.8 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 39.5 сая төгрөг нийт 386.4 сая төгрөгийн орлого санхүүжилттэй ажиллаж, урсгал үйл ажиллагаанд 386.3 сая төгрөгийг зарцуулж, 0.08 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 346.8 сая төгрөг буюу 99.0 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 39.5 сая төгрөгийн орлого хүлээн авч шатахуун, усны ажилчны цалин, гэрэлтүүлгийн зардалд тус тус зарцуулсан бөгөөд 0,07 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 28 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Горим

сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын шийдвэр хэрэгжилтийн хянаж үзэхэд малжуулалтын 32.0 сая төгрөгийн албан шаардлага, “Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн хэрэгжилтийн 8 заалт бүхий 16.9 сая төгрөгийн албан шаардлагын хариуг бүрэн ирүүлээгүй хэрэгжиж шатандаа байгаа зөрчлийг арилгаж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

1. Тээвэр шатахууны зардлын давтан үзэх
2. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт
3. Цалингийн зардлыг нарийвчлан үзэх
4. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

Анхаарах асуудал

- 🚩 Төсөвт байгууллагад хандив тусламж авахыг цаашид зогсоох

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 229.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 72.8 сая төгрөгийн зөрчлийг залруулан 7.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 149.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 72.8 сая төгрөгийн алдааг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Төсвөөс гэрийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багцыг 7.0 сая төгрөгөөр худалдан авч сумын 5 иргэнд үнэ төлбөргүй хүлээлгэн өгч өмчлөх гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу ашиглах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, 41.2.2-т /батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Цалингийн урьдчилгаа 0.1 мянган төгрөгийг дутуу суутган тооцсон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу ашиглах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Төрөөс хариуцах цэвэр усны төлбөрт 15.8 сая төгрөгийг нэхэмжилсэн боловч анхан шатны баримтгүйгээр нэхэмжлэн авч зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад

бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 3.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тээвэр шатахууны тооцоо бодоогүй анхан шатны баримтгүй 17.7 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 3.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн хэмнэлтийн гормыг зөрчиж сумын засаг даргын тамгын газрын төсвөөс гаднын байгууллага хувь хүний 3.1 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан, ЗДНХ-ийн зардлаас 3.2 сая төгрөгийг баяр ёслолын зардалд зарцуулсан нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2-т “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 48.6 сая төгрөгийн 28 мэдээллээс, 41.6 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлан, Татварын тодорхойлолт 51.1 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-т “Аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т “Бүх өр төлбөр” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Малжуулалтын гэрээний дагуу 78 толгой 58.3 сая төгрөгийн үхрийг дараагийн өрхөд шилжүүлээгүй, гэрээг сунгаагүй нь Малчинтай байгуулсан гэрээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халиун сумын Засаг даргын тамгын газар	12	229.1	2	72.8	2	7.1	7	149.2		
5	Дүн	12	229.1	2	72.8	2	7.1	7	149.2		